

Аюулгүй байдлын гадаад орчны өөрчлөлт, цаашдын хандлага, учирч болзошгүй эрсдэл, сорилт

Довчингийн Мягмар

Доктор (Sc.D), профессор, УАБЗ-ийн Шинжээчийн хэсгийн ахлагч, igsmyagmar@gmail.com,
Монгол Улс, Улаанбаатар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл

Аюулгүй байдлын гадаад орчны өөрчлөлтийн тухай

Сүүлийн жилүүдэд их гүрнүүд хооронд бараг гэнэтийн гэж хэлж болох том зөрчил сөргөлдөөн үүсэх нь хэвийн үзэгдэл болох төлөвтэй байна. Үүний улмаас их гүрнүүдийн зүгээс ойлгоход бэрх, олон янзын, түүний дотор олон улсын дэг журам, хэм хэмжээг зөрчсөн, илэрхий түрэмгий үйлдэл ч гаргах боллоо. Хурдацтай өөрчлөгдөх, тааварлахын аргагүй ийм нөхцөл байдалд бусад улс дасан зохицох ёстой болж байна. Энэхүү яаруу сандруу, эмх замбараагүй байдал дунд “олон туйлт ертөнц” гэж нэрлэгдэж буй шинэ төлөв байдал үүсээд байна. Орос болон Азийн зарим улс, тухайлбал Хятад, Энэтхэг өсөн дэвшиж, бэхжиж байхад хүйтэн дайны дараа хэлбэржсэн Өрнөдийн улс хоорондын тогтолцоо эмх замбараагаа алдах тал руугаа болсон. Үүнд: АНУ-ын давамгайлал төгсгөл болж магадгүй шинж тэмдэг мэдрэгдэн, Европын Холбоо задрах эхлэл тавигдаж, улмаар улс орнуудын харьцангуй бие даах эрмэлзэл, соёл иргэншлийн нийтлэг зүйлд тулгуурласан олон улсын шинэ дэг журам бий болох явц ажиглагдаж байгаа болно.

Урт удаан хугацаанд үргэлжилж буй улс хоорондын улс төр, эдийн засгийн хямралын хэд хэдэн таагүй чиг хандлагаас үүдэн олон улсын аюулгүй байдлын хамтын ажиллагаа улам бүр суларч, ээдрээтэй болж байна. Эдгээр чиг хандлага нь технологийн эрчимтэй дэвшил, уур амьсгалын өөрчлөлт гэх мэт улс орон, хүн нэг бүрд хамаарч буй нөлөөлөлтэй хавсран явагдаж байна. Асар олон төрлийн нэн чухал, харилцан нэгнээ өдөөгч энэ бүх хүчин зүйлээс үүдэн өнөөгийн эрин үеийг өмнөхийн адилаар “Хүйтэн дайн”, “Намжмал байдал” гэх мэтийн нэг утгатай үг хэллэгээр тодорхойлох боломжгүй болоод байна.

Геополитикийн нөлөөгөө дэлхий дахин, бүс нутгийн аль алинд өргөтгөх гэсэн их гүрнүүдийн ширүүн өрсөлдөөн, үүний улмаас үүссэн эмх замбараагүй нөхцөл байдлын дунд өөрийн байр сууриа олох гэсэн бусад улсын бодлого, үйл ажиллагаанд алдаж оносон, тогтворгүй, тэмтэцсэн гэж хэлж болох үйлдэл давамгайлах боллоо. Эдгээр өрсөлдөөн, тэмцлийн цаад зорилго янз бүр байна. Цөөхөн жишээ хэлэхэд, Америкийн зүгээс Венесуэл, Украины хямралыг дэвэргэж, Афганистан, Ирак, Зүүн

Азид нөлөөгөө хадгалахыг эрмэлзсэн хэвээр байхад Оросууд өмнө нь ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан улсууд, улмаар Дорнод Европыг өөрийн нөлөөнд оруулахыг эрмэлзэн, Украины салан тусгаарлагчдыг илэрхий дэмжсэн дайн, байлдаан явуулж, Сирид цэрэг, зэвсгийн тусламж үзүүлэн, Венесуэлийг хамгаалж байгаа юм.

Үүний зэрэгцээ энэ бүх зөрчил, сөргөлдөөн, тэмцэл нь эцсийн дүнгээрээ их гүрнүүд хоорондын стратегийн тэнцвэрийг төдийлөн өөрчилж бас чадахгүй байгаа бөгөөд хэвлэл, мэдээллийн хэрэгслээр эсрэг талаа муухай харагдуулах, өөрийгөө магтах замаар дэлхийн олон нийтэд нөлөөлөхийг оролдохоос нэг их хэтэрч чадахгүй байна.

“Оросын түрэмгийлэл”, “Хятадын аюул” хэмээх зүйлүүдийг Өрнөдийн улсууд идэвхтэй ашиглах эрмэлзэлтэй байна. Жишээлбэл: АНУ-д энэ нь бусад улс оронтой харилцахдаа баримтлах улс төрийн гол арга хэрэгсэл болжээ. Энэ улсад бүхий л хэрэг явдалд Орос, Хятадыг буруутгах оролдлого Д.Трампын анхны гэнэтийн гэж хэлж болох ялалтаас үүдэн гарсан боловч Ж.Байдены үед улам даамжирсан бөгөөд Д.Трампыг дахин сонгогдсоноос хойш үргэлжилсээр байна. Өөрөөр хэлбэл: “Хэн Орос, Хятадтай сайн байна тэр манай дайсан” гэсэн хандлага давамгайлсаар байна. Наад зах нь Америкийн дараагийн Ерөнхийлөгчийн сонгууль хүртэл энэ сэдэв тус улсын эрх баригчдын хувьд толгой өвтгөсөн асуудал хэвээр үлдэх нь дамжиггүй. Ийм нөхцөлд Орос, Хятад өөрсдийгөө хэчнээн зөвтгөсөн ч төдийлөн үр дүнд хүрэхгүй бололтой. Харин ч эсрэг үр дүн авчирч, Орос болон Хятад улам бүр Өрнөдийн улсууд дахь “ялзарч буй дэглэм”-ийг өөрчлөх зорилго бүхий бүрэн чадварлаг, боловсронгуй, шийдвэртэй тоглогчийн дүр төрхтэйгөөр дүрслэгдэх боллоо. Үүний дотроос Орос саяхныг хүртэл Америкийн түрэмгий маягийн, бодлогогүй, лалын терроризмыг дэмжсэн агуулга бүхий тогтворгүй байр суурь буюу нэг төрлийн “Америкийн ардчиллын аюул”-аар дэлхийг айлгах аргаар Ойрх Дорнод, Дорнод Европ, Төв Ази, Африкт өөрийн нөлөөгөө бэхжүүлэх, түүнчлэн Хятадтай бүх салбарт, түүний дотор цэрэг-стратегийн чиглэлд ойртон нягтрах эрмэлзэл бүхий чармайлтдаа багагүй амжилт олсоор байна.

Их гүрнүүдийн энэ эмх замбараагүй гэж хэлж болох өрсөлдөөн олон улсын харилцаанд бараг хэвийн зүйл болж хувирсан тул энэ нь цаагуураа тодорхой хэмжээгээр хүчний тэнцвэрийг бий болгож томоохон дайн гарах магадлалыг бас багасгаж байна. Учир нь дайн, дажин нь дайсгалыг улам даамжруулна уу гэхээс шийдвэрлэхгүй гэдгийг улс орнууд улам бүр ойлгох болоод байна. Өнөөгийн орчинд аливаа дайн асар их хор хохирол дагуулах нь тодорхой бөгөөд улс төрийн зорилгоо биелүүлэх ямар ч найдварыг бөхөөнө гэдэг нь хэн бүхэнд тодорхой болсоор байна. Ийм ч учраас улс хоорондын өрсөлдөөнийг аль нэг улсын дотоод нөхцөл байдалд хүчтэй нөлөөлөх олон төрлийн өдөөн хатгалга хэлбэрээр явуулбал дэлхий нийтийн тухайд дайнаас илүү үр дүнтэй байж магадгүй гэсэн нийтлэг ойлголт газар авах болсон.

Өнөөгийн нөхцөл байдлыг “Хүйтэн дайн”-ы үетэй адилтгах нь мөн үндэслэл муутай боллоо. Энэ нь дэлхий дахинд өрнөж буй бүхнийг урьдын адил АНУ-ОХУ-ын сэргөлдөөнөөр тайлбарлах боломжгүй болсонтой холбоотой юм. Энэ хоёр улсын уламжлалт сэргөлдөөний зэрэгцээ Америкийн зүгээс Хятад, Европтой, мөн Энэтхэг нь Пакистан, Хятадтай, тэгвэл Иран Саудын Арабтай тэмцэлдэх гэх зэргээр хүчний олон туйл доторх өөр хоорондын өрсөлдөөн хүчтэй өрнөж байна.

Цаашдын төлөв байдал

Олон улсын өнөөгийн нөхцөл байдалд улс орнуудыг “танайх”, “манайх” эсхүл “сайн”, “муу” хэмээн хуваах өнгөц үзэл том гүрнүүдийн хувьд хэвээр үлдэх төлөвтэй байна. Энэ нь улс хоорондын сэргөлдөөний учир шалтгааныг хялбаршуулсан аргаар тайлбарлах хандлага бий болсонтой уялдаатай бөгөөд, үүний улмаас аливаа улсын дотоод улс төрийн амьдралд өмнө байснаас огт өөр, урьдчилан таамаглахын аргагүй нөхцөл байдал үүсэх, тэр ч байтугай ойлгоход хэцүү, санамсаргүй гэж хэлэхээр үйл явц өрнөх бололцоог бий болгож магадгүй.

ОХУ болон АНУ хоёрын харилцааны тухайд бол сэргөлдөөнтэй байдал нэг хэсэгтээ зонхилсоор байх төлөвтэй. АНУ-ын элитүүдийн ихэнх хэсэг нь өөрсдийнх нь дотоодын асуудалд “хөндлөнгөөс оролцсоных” нь төлөө ОХУ-ын эсрэг өс хонзон өвөрлөн, Москваг ийм төрлийн үйл ажиллагаа дахин хийхээс сэргийлэхийн тулд болон Украины хэрэг явдлаас үүдэн илүү хатуу хориг арга хэмжээ авах нь үргэлжлэх бололтой. Үүний зэрэгцээ ОХУ-ыг АНУ-тай сэргөлдөгчдийг манлайлаасай гэж хүсэхгүй байгаа тодорхой тооны улс төрчид Вашингтонд бас байгаа бөгөөд тэд ОХУ-ын эсрэг үзэл баримтлагчдын түрэмгий маягийн бодлогыг зөөлрүүлэхийг чадах чинээгээрээ чармайсаар байх нь бас тодорхой.

Олон улс орон өөрсдийнхөө хэмжээнд бие даасан байдлаа улам бүр нэмэгдүүлэхийг чармайх болсноос улбаалан тэдгээрийн дипломат бодлого, үйл ажиллагаанд нарийн, няхуур бодож төлөвлөсөн шинэ арга хэлбэр, алхмууд хэрэгцээтэй болох дүр зураг ажиглагдаж байна. Жишээ болгоход Орос-Туркийн хооронд болж буй үйл явдлыг хэлж болох юм. Оросын зүгээс Туркийг өөртэйгөө найрамдалт харилцаатай боловч НАТО-гийн идэвхтэй, дуулгавартай гишүүн улс хэмээн үздэг байсан нь арай өөр болох шинжтэй. Анкара бүс нутагт томоохон дайн үүсгэх аюулт үйлдэл хийх чадавхтай, геостратегийн бодлогын хувьд бие даасан, тусгаар хүчний төв гэдгээ хэний ч өмнө нь таамаглашгүй байдлаа харуулсаар байна.

Орос, Хятадын хувьд энэ ширүүн өрсөлдөөнөөс үүдсэн шинэ сорилт болон ашигтай боломжийн аль алинтай нь учрах төлөвтэй байна. Азид оршиж буй хүчний туйлуудын өөр хоорондын сэргөлдөөн Москвагийн болон Бээжингийн сонирхолд үндсэндээ нийцэж байгаа юм. Орос, Хятад нь өөр хоорондоо болон Монгол, Төв Азитай өргөн газар нутгаар хил залгадаг төдийгүй Солонгос, Японтой ч ойрхон байрлалтай. Иймээс тус бүс нутагт дэлхийн эдийн засгийн төв шилжсэнээр эдгээр улс энэ үйл явцад идэвхтэй үүрэг гүйцэтгэж болох юм. Дэлхийн хүчний туйл Ази

руу шилжих явцад улс хоорондын харилцаанд байгаа хэд хэдэн төрлийн хагарал гүнзгийрэх нь дамжиггүй боловч энэ нь Орос, Хятадад хамаарахаас илүүтэйгээр Европ тивийн аюулгүй байдлын асуудлуудтай холбогдох бололтой. Энэ тохиолдолд Орос сэргөлдөгч талуудын дунд тэнцвэржүүлэх үүрэг гүйцэтгэгч, эсвэл зуучлагч болох, Хятад энх тайвныг баримтлагч үлгэр жишээ болж харагдах боломжтой бөгөөд үүнийгээ ч тэд сайн ухаарч харьцангуй үр дүнтэйгээр ашиглах бололтой.

Хэдийгээр их гүрнүүдийн өрсөлдөөн улам бүр ширүүссээр, Украинд зэвсэгт мөргөлдөөн үргэлжилсээр байгаа боловч олон улс дахь өнөөгийн нөхцөл байдал харьцангуй тогтвортой байгаа бөгөөд дэлхий дахиныг бүхэлд нь хамарсан гүнзгий хагарал гарах шалтаг, шалтгаан үнэндээ хомс байгаа юм. Бид бүгд харилцан холбоотой дэлхийд аж төрж, даяаршлын үр шимийг хүртэж, дэлхий ертөнц жил ирэх тусам улам бүр аюулгүй, тогтвортой болох төлөв чиг бас байгаа юм. Гэхдээ энэ нь улс орнууд цэрэг, армия болзошгүй дайнд бэлтгэхгүй байгаа гэсэн үг бас биш юм. Харин ч тус тусын тусгаар тогтнолыг хамгаалахад цэргийн хүч нэн чухал хэвээр байгаа энэ нөхцөлд тэдний хэн нь ч уг шалтгаанаар өөрийгөө хамгаалах дайнд бэлтгэсээр байх нь дамжиггүй юм. Гэхдээ дээр өгүүлсэн олон улсын харилцаанд улс төрийн өдөөн хатгалга давамгайлах болсонтой уялдаатайгаар улс орнууд бие биеийн эсрэг зэвсэгт түрэмгийлэл, эсхүл сунжирсан дайн, байлдааны ажиллагаа явуулахаас татгалзаж, сүрдүүлсэн маягтай, харьцангуй аюул багатай цэрэг, зэвсгийн гэж хэлж болох өдөөн хатгалгад шилжиж байгаа нь өнөө цагийн олон улсын цэрэг-улс төрийн харилцааны нэгэн шинэ үзэгдэл болж байна.

Эдгээр өдөөн хатгалгад зэвсэг хэрэглэсэн, цэргийн анги, салбаруудын хүчээр явуулах бодит дайнаас ялгаатай буюу цэргийн хүчийг бусад улсын хилийн орчим бөөгнөрүүлэх, цэргийн хээрийн сургуулиудыг тогтмол явуулах, элдэв төрлийн нисгэгчгүй аппарат, тагнуулын хэрэгсэл, тусгай хүчний үйл ажиллагаа, агаарын цэргийн болон пуужингийн хүчний ганц нэг гэнэтийн, оновчтой бөмбөгдөлт, цохилт, радио электрон тэмцлийн хэрэгслийн дайралт гэх мэт хэлбэрүүд улам бүр давамгайлах шинжтэй байна.

Гадаад үүдэл сэдэл бүхий эрсдэл сорилт

Улс төрийн салбарт үүсэж болох эрсдэл сорилт:

- Монгол Улсад стратегийн ашиг сонирхлоо хадгалах, хөрөнгө оруулалт, дэд бүтэц болон эдийн засгийн бусад чухал салбарт давамгай байдлаа бий болгох гэсэн их гүрнүүдийн зөрчил сэргөлдөөн болон тэдгээрийн манай улсын тухайд явуулж буй тус тусын тодорхой чиглэл, зорилго бүхий бодлогын ил, далд хүчтэй нөлөөлөл, үр дагавраас үүдэн Монгол Улсын төр засгийн цэгцтэй бодлого, алдагдах, улмаар аль нэг улс орон, улс төр-цэргийн эвсэл холбоо буюу үндэстэн дамжсан том корпорацуудаас улс төрийн хувьд ямар нэгэн байдлаар хараат байдалд орж болох магадлал бодитой оршиж байна;
- Олон улсын терроризм улам бүр газар авч Төв Ази, Хятадын Шинжаанд тархаж байгаагийн улмаас болон манай улс терроризмын эсрэг барууны

эвсэлд нэгдсэнд дургүйцсэн гаднын хүчний явуулгатай холбоотойгоор энэ эрсдэл ямар нэг хэлбэрээр Монгол Улсад бий болох магадлалтай байна;

- Хонконгд болсон хэрэг явдлын жишгээр Шинжаанд байдал хурцдах, үүнийг Америкийн зүгээс дэмжиж зохион байгуулалттай хэлбэрт оруулах, энэ нь уг бүс нутагтай зах нийлэн орших Монголд хүчтэй нөлөөлөх магадлал бас байна;
- Монгол Улсын геополитик, цэрэг-стратегийн түшиц нутгийн ач холбогдол улам бүр өсөх болсонтой уялдаатайгаар гадаад улсуудын зүгээс манай улсын эсрэг явуулах тагнуулын болон бусад үйл ажиллагаа нэмэгдэх, энэ нь тодорхой чиглэл, зорилготойн зэрэгцээ нийгмийн тодорхой хэсэг бүлэг рүү чиглэсэн агуулгатай болсоор байна.

Эдийн засгийн салбарт үүсэж болох эрсдэл сорилт:

- Монголын эдийн засагт эрсдэл сорилт учруулж болзошгүй, гаднын үүдэл сэдэл бүхий гол аюул бол төр засаг гадаадын өр зээлд ихээр татагдан орж, валютын нөөцөө алдах, барьцаалуулах магадлал өндөр болоод байгаа явдал юм. Ялангуяа Монгол Улсын хөгжилд гадаадын зээл, тусламжийн гүйцэтгэх үүрэг урт удаан хугацаанд их байсан бөгөөд түүний үүргийг хэтрүүлэн үнэлэх, зээл, тусламжийн үр өгөөжийг бага анхаардаг байдал монголчуудад нийтлэг ажиглагддаг болно.
- Монгол Улсын дотоод тогтворгүй байдлын улмаас гадаадын аливаа зээл, тусламжийг замаас нь завших явдал нэлээдгүй гарч байгаагаас үүдэн гадаад улсууд, түүний дотор их гүрнүүд энэ төрлийн үйл ажиллагаанаасаа татгалзах хандлага сүүлийн үед илт ажиглагдах боллоо. Энд Монголд ихээхэн газар авч буй бүх шатны авлигын асуудал голлох шалтгаан болж байна.
- Монгол Улс далайд гарцгүй, төмөр зам, авто зам болон агаарын тээврийн сүлжээ төдийлөн хөгжөөгүй орон. Экспорт, импортын үйл ажиллагаа дийлэнхдээ хөрш хоёр оронтой холбогдсон төмөр замтай холбоотой. Ийм учраас эдгээр улсын зүгээс явуулж болзошгүй бодлого, үйл ажиллагааны улмаас төмөр замын үйл ажиллагаа тасалдах тохиолдолд эдийн засгийн хэвийн үйл ажиллагаа ноцтой алдагдах магадлалтай юм.
- Цахилгаан эрчим хүчний хангалт, эрчим хүчний эх үүсвэрийн импортоор Монгол Улс хойд хөршөөсөө ихээхэн хараат байдалд байгаа нь энэ улсын зүгээс авах ямарваа нэг хориг арга хэмжээний улмаас үүсэх шалтгаанаар энэ үйл ажиллагаа тасалдахад Монгол Улсын эдийн засгийн хэвийн үйл ажиллагаа бүхэлдээ алдагдаж болох талтай юм.
- Удаан хугацааны болон буцалтгүй тусламж гэх гоё сонсогдох нэртэй гадаадын зээл, тусламжийг их хэмжээгээр авах явдал хяналтаас гарах нь эрчим хүч, зам тээвэр, уул уурхай, газар тариалан зэрэг том салбарыг бусад улсын эдийн засгийн хараат байдалд оруулах, эсвэл дааж давшгүй өрөнд нэрвэгдэх, зарим тохиолдолд чухал объект, газар нутгаа барьцаанд

алдахад хүргэх магадлал улам бүр нэмэгдэх боллоо. Эдгээрийн жишээнд: Багануур зэрэг тооцоо судалгаагүй шахам баригдаж эхэлсэн цахилгаан станц, түгээх сүлжээнүүд, зөвхөн хойд хөршийн эрх ашгийг хамгаалсан мэт ойлгогдож буй төмөр замын бүтээн байгуулалт, үндсэндээ гаднын хөрөнгө оруулалтаар, тэднээс авсан зээлээр баригдаж, эцсийн дүндээ ихэнх ашиг нь тэдэнд очих бололтой байгаа Оюу толгойн уурхай, Сэлэнгэ, Булган, Төв зэрэг устай, уултай, ой модтой аймагт олноор бий болж буй, гадаад улсын хөрөнгө оруулалттай гэгдэх газар тариалангийн аж ахуйнууд, Улаанбаатарт төвлөрсөн барилгын том компаниуд, тэдний барьж буй орон сууцны том хорооллууд зэргийг хамааруулж болох байна.

Нийгмийн салбарт үүсэж болох эрсдэл сорилт:

- Манай орны талаар явуулж буй их гүрнүүдийн геостратегийн бодлого улам бүр Монгол Улсыг нийгмийн шинж чанарын хувьд өөрсдийн нөлөөнд оруулах гэсэн чиглэл зорилготой болохын хэрээр үүнээс үүдсэн эрсдэл сорилт нэмэгдсээр байгаа юм;
- Монгол Улсын хөгжил, түүний дотор нийгэм, эдийн засаг, иргэдийн амьдралын түвшин гадаадын дэмжлэг, зээл, тусламжаас ихээхэн шалтгаалсан хэвээр байгаа нь эцсийн дүндээ нийгмийн амьдралд учирч болох аюул заналыг магадлал өндөртэй болгож байна. Ийм байдал бусад буурай хөгжилтэй улсын хувьд бараг хэвийн үзэгдэл боловч хүн ам багатай Монголын хувьд илүү уршигтай байж болох юм;
- Монгол Улсын гадаад харилцаа улам бүр өргөжиж хүн, мал, эд хөрөнгийн урсгал чөлөөтэй болох тутам түүнийг дагалдан элдэв халдварт өвчин тархах аюул бодитой болж байгаа юм. Үүний дотроос КОВИД-19 маягийн элдэв төрлийн шинэ вируст цар тахал, ДОХ-ын болон малын халдварт өвчний аюул улсын хил нэвтрэн орж ирж буй асуудлыг үндэсний аюулгүй байдалд нөлөөлж болох хүчин зүйлийн түвшинд авч үзэх шаардлагатай болж байна.

Соёл иргэнийн салбарт үүсэж болох эрсдэл сорилт:

- Монгол Улсын гадаад харилцаа өргөжих, нээлттэй болох хэрээр бусад орны, юуны түрүүнд америк, солонгос, хятад маягийн амьдрах хэв маяг, эрхэмлэх үнэт зүйлсийн хүчтэй нэвтрэлт гүнзгийрэх, үүнээс үүдэн үндэсний үнэт зүйлсийн үнэлэмжид эргэж буцалтгүй өөрчлөлт гарах, энэ нь монгол хүний удмын сан, угсаа гарваль, төрөлх хэлэнд сөргөөр нөлөөлж болзошгүй байна;
- Хүн төрөлхтний нийтлэг соёлыг дээдлэх, бусад шашныг хүндэтгэх, зарим тохиолдолд шашны гаж урсгалд автах үзэл болон монгол үндэстний төрөлх хэл, соёл, бурхны шашин, ёс заншил, удмын сан, угсаа гарвалиа хадгалан хамгаалах гэсэн эрмэлзлийн хооронд зөрчил, сөргөлдөөн үүсэх, энэ нь улс төржих замаар нийгэмд хуваагдмал байдал үүсгэх магадлал улам бүр нэмэгдсээр байна.

Байгаль орчны салбарт үүсэж болох эрсдэл сорилт:

- Монгол Улс шилжилтийн эмзэг эдийн засагтай орон бөгөөд гадаадын зээл, тусламжид дулдуйдсан, бусад улсын геополитикийн өрсөлдөөний золиос болсон хөгжлийн алдаатай бодлогын улмаас харьцангуй сайн хадгалагдан үлдсэн онгон байгалийн тэнцвэр алдагдах аюул бодитой юм. Тухайлбал: ус, гол мөрөн, агаар мандал, хөрс бохирдох, ой сүйдэх, газрын талхидал, цөлжилт өнөөдөр түгшүүр дэгдээсэн том асуудал болон хувирч байна. Үүнээс газар эдийн засгийн зохицуулалтад ороогүйгээс бэлчээрийн талхидал, хомсдол байгалийн гамшгийн хэмжээнд хүрэх аюултай болж, дээр нь ган зуд тогтмол нүүрлэх болсон нь хүн амын нэлээд хэсгийн амьжиргааны эх үүсвэр болсон мал аж ахуй, газар тариаланд сөргөөр нөлөөлөх хэмжээнд хүрч болох талтай байна.
- Манай мэтийн ядуу буурай улс орны нутаг дэвсгэрийг цөмийн хаягдал болон байгаль орчинд хор хөнөөлтэй бусад материалыг булшлахад ашиглах хандлага чиг бий болж байна.

Аюулгүй байдлын гадаад орчны эрс өөрчлөлтөөс үүдэн Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд учирч болзошгүй эрсдэл, сорилт

Бүс нутагт үүсэх, Монгол Улс татагдан орж болзошгүй эрсдэл, сорилтын тухайд:

- Олон улсын терроризм улам бүр хүрээгээ тэлж Зүүн хойд Ази, Төв Азийн бүс нутгийг, түүний дотор Монгол Улсын нутаг дэвсгэрийг хамрах;
- Улам бүр өсөн нэмэгдэж буй Хятадын эдийн засгийн эрчимтэй хөгжлийг даган Ази тивд цэрэг-улс төрийн нөлөөллөө өргөжүүлэх энэ улсын эрмэлзэл гүнзгийрэх, үүний улмаас үүнтэй ижил төстэй ашиг сонирхол бүхий Америктай ноцтой, өргөн хүрээтэй зөрчилдөхөд хүргэх, үүнд нь Монгол татагдан орох;
- Хоёр Солонгос, Хятад-Тайвань, Энэтхэг-Пакистан хоорондын эсрэг тэсрэг байр суурь, Курилийн арлуудын талаарх Орос-Японы маргаан зэрэг нь улс хоорондын харилцааны тодорхой нөхцөл байдалд зэвсэгт мөргөлдөөнд хүргэх. Энэ нь бүс нутгийг хамарсан шинжтэй болж өргөжин Монголыг ямар нэг хэлбэрээр хамрах;
- 2008 онд тохиолдсонтой төсөөтэй нийтийг хамарсан эдийн засгийн хямрал Ази тив болон Зүүн хойд Азид бий болж энэ нь Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийг сааруулах буюу зогсонги байдалд оруулах;

Уламжлалт буюу цэргийн аюул заналын тухайд:

Ойрын ирээдүйд Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, газар нутагт халдан гаднаас цэргийн хүчээр шууд заналхийлэх аюул үндсэндээ гарахгүй гэж хэлж болохоор байна. Манай улсын олон улсын нэр хүнд сүүлийн жилүүдэд ихээхэн өссөн, хөрш хоёр оронтойгоо элдэв маргаантай асуудлаа аль эрт, олон улсын эрх зүйн

хүрээнд эцэслэн шийдвэрлэсэн, энэ хоёр улстай тогтоосон найрсаг харилцаа, хамтын ажиллагаа өдрөөс өдөрт өргөжин хөгжиж байгаа нь ийм дүгнэлтэд хүргэж байна.

Өмнө өгүүлсэн зүйлүүдийг нэгтгэн дүгнэвэл

Нэг. Дэлхий нийтийг хамарсан даяаршлын үйл явц зарим талаар удаашрах болж, АНУ-ын хэт давамгайлал сааран, үүнтэй уялдаатайгаар улс хоорондын харилцаа дахин олон туйлт хэлбэрт шилжих төлөвтэй байна. Соёл иргэншлийн гэж хэлж болох эдгээр туйлын тоонд юуны өмнө АНУ тэргүүтэй улс төр, цэргийн холбоотон улсууд, ОХУ, түүнийг дагасан хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд багтаж байсан улсыг хамааруулж болохоор байна.

Үүний зэрэгцээ Хятадын бие даасан, гэхдээ Зүүн Өмнөд Азийн болон Африкийн зарим улсыг оролцуулсан геободлого улам бүр өргөжих болж, Баруун Европын харьцангуй бие даах эрмэлзэл үргэлжилсээр, Энэтхэгийн хурдацтай хөгжил, харьцангуй бие даасан эрмэлзэл, ОХУ-БРИКС-ийн болон ОХУ-Ойрх Дорнод, Хойд Африкийн улсуудын улс төр, эдийн засаг, цэргийн харилцаа, Лалын ертөнцийн болон Латин Америкийн улсуудын нэгдэх үйл явц алхам, алхмаар урагшилсаар байна.

Цаг хугацааны хүчин зүйлтэй өрсөлдөн явагдаж буй энэ үйл явц шийдвэрлэхэд амаргүй олон асуудлыг араасаа дагуулж, бүс нутгуудад хадгалагдсаар буй хуучин сөргөлдөөнийг улам бүр гүнзгийрүүлж, үүний зэрэгцээ янз бүрийн үүдэлтэй олон шинэ сорилт, эрсдэлийг бий болгох төлөвтэй байна.

Хоёр. Зүүн Хойд болон Төв Азид олон улсын байдал ойрын жилүүдэд ерөнхийдөө тэнцвэр хадгалагдсан, тогтвортой байх төлөвтэй боловч Орос-Америкийн болон Хятад-Америкийн сөргөлдөөний улмаас энэ бүс нутгийн аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй хэд хэдэн шинэ хүчин зүйл үүсэх магадлалтай байна. Үүнд:

- Хэдийгээр сүүлийн жилүүдэд АНУ-ын зүгээс Солонгосын хойгийн асуудлыг БНАСАУ-тай шууд харилцах буюу хоёр улсын хооронд дээд хэмжээний уулзалт зохион байгуулах аргаар шийдвэрлэхээр ихээхэн чармайлт гаргаж, түүнчлэн Умард, Өмнөд Солонгос өөрсдөө ихээхэн санаачилгатай байгаа боловч энэ үйл явц олон улсын гэрээ хэлэлцээрээр баталгаажих явдал ирээдүй цагийн асуудал хэвээр байна.
- Орос, Хятад хоёр Төв Евроазийн, түүний дотор Төв Ази болон эргэн тойрны орон зайд олон улсын аюулгүй байдлын шинэ харилцааг бий болгох талаар идэвхтэй чармайлт гаргах болж, энэ зорилгоор байгуулсан ШХАБ-ыг Энэтхэг, Пакистанаар бэхжүүлж, Иран, Беларусь гэх мэт улсаар өргөтгөсөн нь улам бүр газар авах шинжтэй байна. Үүний өөр нэг илэрхийлэл нь Оросын санаачлан байгуулсан Евроазийн эдийн засгийн холбоо болон Хятадын санал болгож буй “Бүс ба Зам” төслийн хүрээнд хийж буй ажлууд юм.

Гурав. Өнгөрсөн 30 гаруй гаруй жилд олон улсын хамтын нийгэмлэгт Монгол Улсын эзлэх байр суурь, нэр хүнд өсөн бэхжиж, дэлхийн том гүрнүүд, түүний дотор

хөрш орнууд манай улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдалд хүндэтгэлтэй хандан, эрх тэгш, харилцан ашигтай байх зарчмаар, стратегийн түншлэлийн түвшинд хамтран ажилладаг болоод байна. Үүний зэрэгцээ Монгол Улсын аюулгүй байдлын гадаад орчин, дэлхий дахин, бүс нутгийн цэрэг-стратегийн болон геополитикийн нөхцөл байдалд амаргүй гэж хэлж болох томоохон өөрчлөлтүүд бас гарлаа. Монгол Улс аливаа аюул заналаас бүрэн тусгаарлагдсан гэж бодож сэтгэл тайвшрах цаг хараахан болоогүй байна. Дэлхийн янз бүрийн бүс нутаг, түүний дотор Зүүн Хойд болон Төв Азид улс хоорондын ашиг сонирхлын зөрчил, сөргөлдөөн хадгалагдсаар, учир шалтгаан нь улам бүр нарийн төвөгтэй бөгөөд олон янз болж, улс үндэстэн хоорондын харилцаанд, ялангуяа ОХУ, АНУ-ын хооронд үл эвлэрэх хандлага хадгалагдсаар байна.

Монгол Улсын ашигт малтмалын асар их баялаг болон бидний баримталж буй ардчилсан улсуудын эгнээнд нэгдэн орох гэсэн хүчтэй эрмэлзэл дэлхийн их гүрнүүдийн анхаарлыг сүүлийн жилүүдэд татах болж, улмаар манай улс тэдгээрийн улс төр, эдийн засаг, аюулгүй байдал, геостратегийн сөргөлдөөний шинэ талбар болон хувирах магадлал хүчтэй мэдрэгдэж эхэллээ. Энэ нь нүүрс, зэс, газрын ховор элемент, уран болон бусад ашигт малтмалын асар том ордууд нээгдсэн, тэдгээрийг ашиглах асуудлыг монголчууд бусад улс оронд нээлттэй болгосонтой ч шууд холбоотой байна.

Changes in the External Security Environment, Future Trends, Potential Risks and Challenges

Myagmar Dovchin

Prof, Dr (Sc.D), Major General. Head of The Expert Group of The
National Security Council of Mongolia, igsmyagmar@gmail.com
National Security Council, Ulaanbaatar, Mongolia

Received: December 5, 2025 | Accepted: December 23, 2025 | Published online: December 30, 2025



© The Author(s) 2025
<https://creativecommons.org/licenses/by/4.0/>.